

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

Ц.Баяндалай

ДХИС-ийн Удирдлагын академийн 8012 дугаар дамжааны суралцагч, магистрант,
хошууч

Товч агуулга: Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүний хүчинд тулгуурласан уламжлалт аргаас татгалзаж, багасган түүний орон зайг орчин үеийн дэвшилтэд техник, технологийн ололтод суурилсан эдийн засгийн хувьд үр ашигтай, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн автомашин техникийг ашиглах нь байгууллагын хөгжлийн үндсэн чиглэл болж байна.

Abstract: The border guard organization has rejected the traditional methods based on human power and reduced its space in the implementation of its legally mandated functions. The use of economically efficient and human labor-relieving vehicle technology based on modern advancements in technology and technology has become the main direction of the organization's development.

Түлхүүр үгс: Улсын хил хамгаалалт, техник, технологи

Key words: State border protection, technique, technology

Оршил

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дархан хил зорилт 7.2, I үе шат (2021-2030)-нд хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үе¹ гэж заасан байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн

31.2 дахь заалт: Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор

улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ.²

31.3 дахь заалт: Газар, усан дээрх улсын хилийг улсын хил хамгаалах байгууллага, агаарын хилийг зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална гэж тус тус заасан.

Судлаачдын хил хамгаалалтыг дээшлүүлэх, аюулгүй байдлыг сахин хамгаалах чиглэлээр олон бүтээлүүд байдаг ба түүн дотор техник, технологийг ашиглах талаар зарим нэг санаанууд орсон боловч, тухайн

¹ “Алсын хараа 2050” хөтөлбөр Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлого

² Монгол Улсын хилийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017 он.

үеийн технологийн хөгжилд тулгуурласан тул орчин үеийн нөхцөл байдалтай холбогдохгүй байна.

Иймд “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан “Дархан хил” зорилтод “Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үе”-д тусгагдсан энэхүү сэдвийг судлах хэрэгцээ шаардлага байгаа гэж үзэж байна.

Нэг. Улсын хил хамгаалалтын авто техникийн хангалт, зохион байгуулалтын түүхэн уламжлал, туршлага

Хил хамгаалах байгууллагын авто техникийн хангалтын удирдлага, зохион байгуулалтын онол арга зүйн талаарх ойлголт нь цэргийн хангалт гэдэг ойлголтын бүрэлдэхүүн тул түүний хүрээнд авч үзэх нь зүйтэй.

Улсын хил хамгаалалт нь судалгааны объект, судлах зүйлтэй байдгаараа онолын шинжийг агуулдаг.

Улсын хил хамгаалалтын онол нь:

1.Хил хамгаалалтын ерөнхий онол

2.Хил хамгаалалтын урлагийн онол

3.Хилийн цэргийн байгуулалтын онол

4.Хилийн болон хил хамгаалалтын түүхийн онол

5.Ар тал хангалтын онол

6.Цэргийн сургалтын онол

7.Хилийн цэргийн удирдлагын онол гэсэн бүтэцтэй байдаг.¹

Хилийн цэргийн ар тал хангалтын онол нь улсын хил хамгаалалтын онолын бүрэлдэхүүн хэсэг болохынхоо хувьд өөрийн судалгааны объект, судлах зүйлтэй байна.

Хилийн цэргийн ар тал хангалтын онол судалгааны объект нь улсын хил хамгаалалтын болон хилийн анги, салбарын ар тал мөн гэж үзэж байна.²

Улсын хил хамгаалалтын ар талын онол нь судалгааны объект, судлах зүйлтэй байна. Үүнд:

- Байлдааны зэвсэг, техник, сэлбэг хэрэгсэл түүний хадгалалт, хамгаалалт, цуваажилтыг нормоор зохион байгуулах;

- Материал-техникийн хангалт, дэд бүтцийг хөгжүүлэх, түүний бүрэн бүтэн байдлыг сахиулах, засварлах.;

- Зам харилцааг сэргээн засварлах, бэлтгэх, ашиглах техникийн хангалт хийх;

- Нисэх хүчний хангалтыг зохион байгуулах;

- Цэргийн алба хаагчид болон бусад хүч хэрэгсэл, материал хэрэгслийн хангалтыг зөөвөрлөх;

- Байлдааны зэвсэг, техникийг ашиглах, байлдааны болон тусгай ажиллагааны явцад эвдэрсэн, гэмтсэн зэвсэг, техникийн татан гаргах, сэргээн засварлах;

- Цэргийн анги байгууллагын мал, эмнэлэг, эрүүл ахуй хангалт, барилга байгууламжийн засвар үйлчилгээ, инженерийн шугам сүлжээний бүрэн бүтэн байдал, бие

¹ Даш.П “Хил хамгаалалтын онол”. УБ.,2002.21 дэх тал

² Даш.П “Хил хамгаалалтын онол”. УБ.,2002.12 дах тал

бүрэлдэхүүний ахуй хангамж, хориглолт, халхлалтыг зохион байгуулах, материал-техникийн хангалтыг удирдах;

Ар тал техникийн хангалтын үндсэн үүрэг

Цэргийн зэвсэг техник, материалын нөөцөөр орон тоо, нормд хүртэл хангах, хадгалах, хамгаалах, засварлах сэргээн босгох;

Улсын хил хамгаалалтын албаны хангалт нь улсын хил хамгаалалтын онолын ар тал хангалтын онолын нэг бүрэлдэхүүн хэсэг болдгоороо хил судлалын шинжлэх ухааны нэг судлагдахуун болдог.

Улсын хил хамгаалалтын албаны хангалтыг;

Ердийн үед-Албаны

Байлдааны үед-Байлдааны хангалт гэж нэрлэж ирсэн.. Энэ нь үндсэндээ зарчмын хувьд ямар нэгэн ялгаагүй бөгөөд Байлдааны хангалтыг Хил хамгаалах албанд 1990-ээд оноос хойш алба-байлдааны, албаны хангалт хэмээн зөөлрүүлэн нэрлэн хэрэглэж байна.

Ар тал-техникийн хангалтыг зохион байгуулах гэдэг нь: Түүнийг бэлтгэх, ар талын байгууламжийг бий болгох, тээвэрлэлт, татан гаргалтын замыг бэлтгэх, бүх төрлийн материал хэрэгслээр хангах түүнийг тээвэрлэх, зэвсэглэл техникийг ашиглах, сэргээн босгох, төрөл бүрийн албадын үйл ажиллагаа, хүч хэрэгслийг тухайн ангийн ар тал техникийн хангалтад зохицуулах, ар тал техникийн хэрэгслийн харуул, хориглон хамгаалалтыг зохион байгуулах,

удирдлагын системийг дэлгэх зэрэг цогц арга хэмжээг хэлнэ.¹

Техникийн хангалт гэсэн үгийг нэг л үг шиг ойлгож хэрэглэхдээ саланги байдлаар ярьж хэлж хэвшихгүй байх шаардлагатай. Үүний тулд дагалдан хэрэглэгдэх үгсийг болон тэдгээрийн утгыг сайтар нухацтай ойлгосон байх хэрэгтэй.

Үүнд;

- Зэвсэглэл-зэвсэг, галт хэрэгсэл, автомашин, авто техник, хуягт танкийн болон автохуягт, тракторын техник, инженерийн техник, бусад албадын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж

- Зэвсэг- хувь хүний, бүлгийн, хүнд, хөнгөн зэвсгүүд

- Автомашин- суудлын, ачааны, тусгай зориулалтын, автобус, микро автобус

- Авто техник-автомашин, төрөл бүрийн чиргүүл, цахилгаан үүсгүүр

- Хуягт танкийн техник хуягласан гинжит болон дугуйт байлдааны зориулалтын машин техник, танк, мотоцикл, цахилгаан үүсгүүр

- Авто хуягт, тракторын техник-дугуйт байлдааны хуягт машинууд (БТР-60ПБ, БМП, БРДМ-2М), чирэгч машин, автомашин, трактор, мотоцикл, цахилгаан үүсгүүр

- Албадын техник хэрэгсэл гал тогооны чирэх хэрэгслүүд, засвар, тусгай зориулалтын техникүүд

- Тээврийн хэрэгсэл автомашин, трактор, чиргүүл, галт тэрэг, онгоц, нисдэг тэрэг гэх зэрэг.

¹ Б.Батбаатар, Ж.Намнан “Цэргийн ар талын удирдлага, төлөвлөлт” УБ, 2008 он 23 дах тал

Хил хамгаалах байгууллагын техникийн шинэчлэлт, сэргээн сайжруулалт, удирдлага зохион байгуулалтын асуудал гадаад орнуудаас бүрэн хамааралтай харагдаж байгаа учир гадаадын өндөр хөгжилтэй орнуудын техникийн шинэчлэлт, хангалтын төлөвлөлтөөс өвөрмөц онцлогтойгоор өөрийн орны онцлогт тохирсон туулах чадвар сайтай, зорчигчдын аюулгүй байдлыг бүрэн хангасан, эдийн засгийн хувьд үр ашигтай, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн автомашин техникийг ашиглах нь байгууллагын хөгжлийн үндсэн чиглэл болж байна.

Аливаа улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал ялангуяа улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үйл хэрэгт хүн төрөлхтний өөрийнх нь хүчин чармайлтаар бий болсон авто техник түүний хангалт шийдвэрлэх нөлөө үзүүлж байна.

Сансар, мэдээлэл, даяаршлын ХХI зуунд хүн төрөлхтний гурав дахь мянганы зорилтуудыг НҮБ-аас дэвшүүлсэн энэ үед бүх нийтийн ердийн хэрэгцээ болсон авто техникийг хилчдийн өдөр тутмын хэрэгцээ болгож ашиглах, улсын хилийн аюулгүй байдлыг хангах зорилт хэзээ хэзээнээс илүү хурц тавигдах боллоо.¹

Анх 1925 оны 07 дугаар сарын 15-ны өдөр “Монгол тээх нэвтрүүлэх газар”-ыг 7 машинтайгаар байгуулсан нь манай улсын түүхэнд орчин үеийн механикжсан анхны байгууллага бий болсон түүхтэй.²

Дотоодыг хамгаалах ерөнхий газрын даргын 1933 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн тушаалаар хилийн цэрэг төвлөрсөн хангалтад шилжиж, түүнийг удирдах бэлтгэлийн тасгийг дотоодыг хамгаалах газрын Хязгаарыг хамгаалах ба цэргийн хэлтсийн бүрэлдэхүүнд байгуулж, улмаар 1936 онд бэлтгэн нийлүүлэх газар болгон өргөтгөн зохион байгуулсан байна.³

Хоёр: Хил хамгаалах байгууллагын авто техникийн хангалтын

өнөөгийн нөхцөл байдал, анхаарах асуудал

XX-XXI зуунд шилжих хугацаанд авто техникийн хангалт ашиглалтад шинэ үе шат эхэлж байна.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод “Улсын хилийн бүс зурвас, боомт газарт орчин үеийн шаардлагад нийцсэн холбоо, хяналт, дохиолол, зам тээвэр, инженер техникийн байгууламж бүхий хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх” мөн “хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалтай байлгах” гэж эрх зүйн үндэс тавигджээ. Энд авто техникийн алба түүний хилийн цэрэгт үйлчлэх хангалт чухал байр эзэлж байгаа нь тодорхой харагдаж байна.

Хилийн тухай шинэчлэгдсэн хуульд авто техникийн хангалтын чиг үүрэг хангалттай тусгагджээ. Тус хуульд хил хамгаалах байгууллагын

¹ Н.Отгонбаяр “Менежмент” УБ. 2007 он 19 дэх тал

² “Армийн автомашин хангалт” УБ. 1984 он 9 дэх тал

³ Лхагва.Б “Хилийн цэргийн ар тал хангалтын үйл ажиллагааны онол, практикийн асуудал”, 2005 он. 102 дах тал

бүрэн эрхийг тодорхойлохдоо “хилийн бүсэд инженер, техникийн болон зам харилцааны байгуулалт барих эрхтэй болохыг тодотгож өгчээ”.

Улсын хилд ашиглах техникийг уул, говь, цөл, ус, намаг зэрэг байгалийн бэрхшээлийг харгалзахгүй туулах зориулалтын техникээр хангаж байна.

Ойрын жилүүдэд Монгол Улсын цэрэг техникийн шинэчлэлт, сэргээн сайжруулалт нь гадаад орнуудаас бүрэн хамааралтай харагдаж байгаа учир гадаадын өндөр хөгжилтэй орнуудын техникийн шинэчлэлт, хангалтын төлөвлөлтөөс өвөрмөц онцлогтойгоор өөрийн орны онцлогт тохирсон техникийн шинэчлэлтийг хийх шаардлага зүй ёсоор тулган гарч байна.

Хил хамгаалах байгууллагын авто техникийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зүйн хэрэг юм. Хил хамгаалах байгууллага 184 төрөл загварын 1960 орчим нэгж автомашин техникийг улсын хил хамгаалалтад ашиглаж байна.

Авто техникийн хангалт гэдэг ойлголтыг олон хэлбэрээр тодорхойлсон байдаг боловч хил хамгаалах байгууллагад мөрдөгдөж байгаа удирдлагын баримт бичигт дараах байдлаар томъёолон ашиглаж байна.

Хил хамгаалах байгууллагыг авто техник болон эд хэрэглэлээр хангах, тэдгээрийн ашиглалт ба сэргээн засварлах, бие бүрэлдэхүүний техникийн болон тусгай бэлтгэлжилтийг хамарсан арга хэмжээнүүдийн цогц юм.

Өнөөдрийн байдлаар хил хамгаалах байгууллагын хэмжээнд

ашиглагдаж байгаа техникийн 76.1 хувийг авто техник эзэлж байна.

Монгол Улсын хил хамгаалах практикаас харахад техникийн шинжлэх ухаан машины үйлдвэрлэл эрчимтэй хөгжих нөхцөл хараахан бүрдээгүйгээс хөгжилтэй аль нэг улсын техникийг худалдааны болон буцалтгүй тусламжийн хэлбэрээр авч хилийн албаны хэрэгцээг хангаж байна.

Авто техникийн хангалт, үйлчилгээг төлөвлөж хэрэгжүүлэхэд эдгээр хүчин зүйлүүдийн нөлөөллийг зайлшгүй харгалзан үзэх шаардлага гарч байгаа юм. Шинээр нэвтэрсэн техник тодорхой хугацааны дараа хуучирч хэрэглээнээс гардаг үүнийг дагаад дараагийн үеийн техник технологитой харьцах техникчдийн ур чадвар дутагддаг.

Монголчууд ердийн хөсөг (морь, тэмээ) ашиглан улсын хил хамгаалалтыг одооч зохион байгуулсаар байна. XXI зуун бол шинжлэх ухаан, техник, сансар, инновац, нано технологитой холбогдсон нийгмийн бүх салбарт, тэр дотроос улсын хилийг хамгаалах аюулгүй байдлыг хангахад авто техник шийдвэрлэх хэрэгсэл болсон орчин үед амьдарч байна.

Техник хэрэгслийн бүрэн шинэчлэлийг нэг дор хийх бололцоогүй байгаа тул бүсийн онцлогт тохируулан туулах чадварыг нэмэгдүүлэх нэмэлт тоноглол, инженерийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах, нэмэгдүүлэх, дээшлүүлэхэд ашиглах техникийн дагалдах хангалтууд сэлбэг хэрэгслийг бүсийн нөхцөлд тулгуурлан дотоод нөөц бололцоог ашиглан авч хэрэгжүүлэх нь чухал байна.

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүний хүчинд тулгуурласан уламжлалт аргаас татгалзаж, багасан түүний орон зайг орчин үеийн дэвшилтэд техник, технологийн ололтод суурилсан дэвшилтэд туулах чадвар сайтай, зорчигчдын аюулгүй байдлыг бүрэн хангасан, эдийн засгийн хувьд үр ашигтай, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн автомашин техникийг ашиглах нь байгууллагын хөгжлийн үндсэн чиглэл гэж үзэж байна.

Улсын хил хамгаалалтад орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, улсын хилийн аюулгүй байдлыг тасралтгүй хамгаалах нөхцөл боломжийг бүрдүүлэн, инженерийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах, нэмэгдүүлэх, дээшлүүлэх механизм, бага оврын цахилгаан автобус, цахилгаан суудлын авто машин, нэмэлт тоноглолын хангалтыг зохион байгуулах цэрэг техникийн бодлого шаардлагатай байна.

Санал

Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил

хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үеийн. Хүрээнд техникийг шинэчлэлийг нэмэгдүүлэх, судалгааны ажлыг эрчимжүүлэх;

Техник хэрэгслийн бүрэн шинэчлэлийг нэг дор хийх бололцоогүй байгаа тул бүсийн онцлогт тохируулан туулах чадварыг нэмэгдүүлэх нэмэлт тоноглол, инженерийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах, нэмэгдүүлэх, дээшлүүлэхэд ашиглах техникийн дагалдах, сэлбэг хэрэгслийг бүсийн нөхцөлд тулгуурлан дотоод нөөц бололцоог ашиглан авч хэрэгжүүлэх;

3.”Цэрэг техникийн бодлого” удирдлагын баримт бичиг боловсруулан албанд ашиглах

Эх сурвалжийн жагсаалт

- Н.Отгонбаяр “Менежмент”

УБ. 2007 он 19 дэх тал

- “Армийн автомашин хангалт” УБ. 1984 он 9 дэх тал

- Лхагва.Б “Хилийн цэргийн ар тал хангалтын үйл ажиллагааны онол, практикийн асуудал”, 2005 он. 102 дах тал